



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын болон харьяа орон нутгийн экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын үндсэн хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодын балансаас балансад шилжүүлэх жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Харьяа гаалийн газар, хороодын дарга, ахлах нягтлан бодогч нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Комисс томилон хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, хяналт тавих.


2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх.

2.3 Барилгын доорх газар эзэмших эрхийг хүлээн авч буй төрийн өмчит байгууллагын нэр дээр эзэмшигчийг шилжүүлэн авах, үнэлж данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах.

2.4 Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор багтаан ирүүлэх.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АСРАЛТ

1439501 0492